



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/05

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 035/01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссоос 2019 оны 11 дүгээр сард аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 16 суманд эрсдэлийн түвшин их, 2 сум дунд 1 сум бага эрсдэлтэй гарсан тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, гадны аймагт оторлож буй малчдад нүүрс, эмийн багц тараах, оготно устгал зэрэгт нийт 518196090 (Таван зуун арван найман сая нэг зуун ерэн зургаан мянга ер) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг аймгийн гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах арга хэжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100009

Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн 4/05 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Нийт үнэ (мянган төрөг)
1.	Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс нийлүүлэх	30000	300000.0
2.	Гадны аймагт отроор яваа малчдад эмийн багц тараах	1854	74160.0
3.	Малчдад долооц тараах	1000	5500.0
4.	Гадны аймагт отроор яваа малчдад нүүрс тараах	-	38536.09
5.	Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно устгалд	-	100000.0
6.	НИЙТ ДҮН	-	518196.09

-оОо-